



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 514

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.5, 6.6, 6.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Хөвсгөл-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 4 нэрийн, нийт 123,275,624.00 (нэг зуун хорин гурван сая хоёр зуун далан таван мянга зургаан зуун хорин дөрвөн) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. "Хөвсгөл-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Галбадрахад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, эргэлтийн хөрөнгөд орлогод авах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Акталж данснаас хассан тээврийн хэрэгслийг улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2021 оны 11 дүгээр сарын 11-ний
өдрийн 514 дүгээр тогтоолын хавсралт

**"Хөвсгөл-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд
бүртгэлтэй, акталж данснаас хасах хөрөнгийн жагсаалт**

№	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн ашиглалтад орсон он	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/
1	Донгфенг маркын ачааны автомашин, 18-78 ХӨВ улсын дугаартай, арлын дугаар- LGAWAHAAH39660403	2009/2009	1	34,425,208.00	34,425,208.00
2	Донгфенг маркын ачааны автомашин, 18-79 ХӨВ улсын дугаартай, арлын дугаар- LGAWAHAAH19660405	2009/2009	1	34,425,208.00	34,425,208.00
3	Донгфенг маркын ачааны автомашин, 18-82 ХӨВ улсын дугаартай, арлын дугаар- LGAWAHAAH496604054	2009/2009	1	34,425,208.00	34,425,208.00
4	Краз 255 маркын механизм, 6455 ХӨА улсын дугаартай, арлын дугаар- 370841	1980/1988	1	20,000,000.00	20,000,000.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		4 (дөрөв)		123,275,624.00 (нэг зуун хорин гурван сая хоёр зуун далан таван мянга зургаан зуун хорин дөрвөн)